



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 13

Өмнөдэлгэр сум

**Сумын газар зүйн нэрийн мэдээллийн сангийн
нэрийн жагсаалтыг уламжлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.5.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Ерөнхийлөгчийн 2017 оны 186 дугаар зарлиг, Монгол Улсын Их хурлын 2003 оны 42 дугаар тогтоол, Геодези, зураг зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Тавдугаар Хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1.Өмнөдэлгэр сумын газар зүйн нэрийн мэдээллийн санд багтсан нэрийн жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Газар зүйн нэрийг тодотгох, мэдээллийн сан байгуулах ажлын хүрээнд тогтоогдсон газар зүйн зөрүүтэй нэрс болон Улсын Их Хурлын тогтоолоор баталгаажаагүй нэрсийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар, Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан боловч байршил тодорхойгүй, үг үсгийн зөрүүтэй бичигдсэн, дарагдаж устаж үгүй болсон, сумын хилийн цэсийн гадаа байршсан нэрсийг Улсын Их Хурлын тогтоолоос хасуулах нэрсийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар баталж уламжилсугай.

2.Газар зүйн зөрүүтэй нэрс болон Улсын Их Хурлын тогтоолоор баталгаажаагүй нэрсийг зохих хуулийн дагуу санал дэвшүүлэхийг сумын Газар зүйн нэрийн салбар зөвлөлд даалгасугай.

3.Газар зүйн нэрийн мэдээллийн санд багтаж Улсын Их Хурлаас баталсан газар зүйн нэрийг албан хэрэг, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд мөрдүүлэх, ард иргэдийн дунд сэргээн хэвшүүлэхийг сумын Газар зүйн нэрийн салбар зөвлөлд үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж жилийн эцэст иргэдийн төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Р.Энхтөр)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ